



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/105

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хийгдсэн Сумын төвийн шинэ суурьшлын бүсэд шинээр байгуулагдах цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих, нийтийн эзэмшлийн талбайн хашааг засварлах гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Гишүүд: Г.Гөлгөө (Байгаль хамгаалагч)  
Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын  
нярав)  
Л.Балжинням (иргэний төлөөлөл)  
Х.Дагвадулам (иргэний төлөөлөл)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Г.Бямбагарав)-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчид бүртгэх шаардлагатай хөрөнгийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН